

Монгол (törü)-ийн инвариант чанарын ойлголт ба үндсэн хуулийн шүтэлцээ

Шараагийн Бямбаа, магистр
Ulaanbaatar, Mongolia, byambaa.uv@gmail.com

Article history

Received : 2025-08-31

Accepted : 2025-11-30

Published : 2025-12-31

Түлхүүр үгс

инвариант чанар, *törü*
домгийн сэтгэлгээ,
хамтын ухамсар, Үндсэн
хууль, *state*, ардчилал,
орчлонгийн хууль,
парадокс, системийн
сэтгэлгээ

Хураангуй: Энэхүү судалгаанд Монгол төрийн инвариант чанарыг домгийн үеийн сэтгэлгээ, хамтын ухамсар, системийн сэтгэлгээний онолын хүрээнд судлан, Үндсэн хуулийн нэр томъёоны орчуулга болон ардчилалын уламжлалтай огтлолцуулан шинжилсэн. Судалгааны үр дүнд Монголын уламжлалт төрийн тухай ойлголт нь *Нууц товчоо*-нд тэмдэглэгдсэн *törü* хэмээх ойлголттой уялдаж, тэнгэр-хүн-газар гурвалын зохирол дээр тулгуурласан амьд, оюун санааны тогтолцоо болохыг тогтоов. Харин барууны *state* онол нь өмч, хил, хууль эрх зүйн механик зарчмууд дээр суурилдаг. Энэ хоёр өөр онтологийн түвшний ойлголтын зөрчил нь Монгол Улсын Үндсэн хуульд нэр томъёоны орчуулгын түвшинд туссан нь төр-иргэн-нийгмийн итгэлцэлд сөргөөр нөлөөлж буйг харууллаа. Судалгааны ач холбогдол нь төрийн инвариант чанарын ойлголтыг тодорхойлох замаар Монгол төрийн эрх зүйн философийг шинээр сэргээх боломжийг нээж буйд оршино.

The invariant nature of mongolian *törü*: constitutional interrelations

Byambaa Sharaa, (LL.M.)
Ulaanbaatar, Mongolia, byambaa.uv@gmail.com

Keywords

invariance, *törü*, statehood,
mythological thinking,
collective consciousness,
Constitution, state,
democracy, cosmic law,
paradox, systems thinking

© The Author(s), 2025



Abstract: This study investigates the invariant nature of Mongolian *törü*-hood through the frameworks of mythological thinking, collective consciousness, and systems theory, while analyzing its intersections with constitutional translation and democratic traditions. The findings reveal that the traditional Mongolian concept of statehood is closely linked to *törü*, as recorded in *The Secret History of the Mongols*. Unlike the Western notion of the *state*, which is based on property, borders, and legal mechanisms, *törü* embodies a holistic worldview grounded in the harmony of Heaven, humans, and earth. The conflict between these two ontological levels is reflected in the terminology of the Mongolian Constitution, negatively affecting trust among state, citizens, and society. The significance of this study lies in identifying the invariant principle of statehood, thereby opening possibilities to revitalize the legal and philosophical foundations of Mongolian statehood

1.ОРШИЛ

Монгол *törü* (цаашид төр гэнэ)-гийн тухай уламжлалт ойлголт нь улс төрийн байгуулал, засаг захиргааны бүтэц бус орчлонгийн жам ёстой салшгүй холбоотой гүний үзэл санаа юм. Энэ нь Монголын домгийн сэтгэлгээ, түүхэн уламжлал, хэлний хэрэглээнд гүн шингэж олон зуун жил дамжин хадгалагдсан байдаг. Монголын “төр” ойлголтын уг гарвал нь “төрөх” үйл үгтэй холбоотой бөгөөд зөвхөн хувь хүний амьдралын эхлэлийг бус овог аймгийн нэгдэл, газар орны эхлэл, ертөнцийн бүх бүтцийн эх цэгийг илэрхийлдэг. Тиймээс Монгол төр гэдэг ухагдахуун нь аливаа улс төрийн байгууллаас давсан бүхнийг холбож тогтоогч орчлонгийн зохиролын архитеп утгыг агуулдаг.

Энэ уламжлалт ойлголт нь орчин үеийн Үндсэн хууль дахь барууны *state* ойлголтыг “төр” гэж орчуулсантай сөргөлдөж байна. 1992 оны Үндсэн хуулийн оршил хэсэгт “Монголын ард түмэн бид... төрт ёсны түүхэн уламжлалаа нандигнан өвлөнө...” хэмээн заасан нь төрийн уламжлалт үзэл ба ардчилсан тогтолцоог холбох гүүр болсон ч нөгөө талаас “*state=mep*” гэсэн орчуулга нь системийн түвшний зөрчил үүсгэсэн.

Ард түмний ухамсарт төр нь “төрийн сүлд минь өршөө” гэх ариун нандин (сакрал) ойлголт хэвээр оршсоор байхад хууль эрх зүйн түвшинд төр нь барууны институтын механик бүтэц болж хуульчлагдсан нь өнөөдрийн улс төрийн итгэлцлийн гол эх сурвалж болж байна.

Өмнөх судлаачдын бүтээлүүдэд Монголын уламжлалт “төр” ойлголтыг өөр өөр өнцгөөс тайлбарласан байдаг. Жишээлбэл, К.Хамфри 13 дугаар зуунаас өнөөг хүртэлх Монголын түүхэн дэхь “төр” ойлголтын түүхэн хувьслын явцыг судалж, Монгол төрийн легитим байдлыг сакрал шинжээр буюу “төрийн

сүнслэг онол” (*spiritual theory of the state*) гэж дүгнэсэн (Хамфри, К, Хүрэлбат. А, - 2004). Т.Д.Скрынникова “Монголын нууц товчоо”-нд гардаг төрү/төрэ үгсийг судлан шинжилж тэнгэрийн хуультай холбон тайлбарлаж, (Скрынникова, Т. Д. 2000) “улс мөхөвч төр үлдэнэ” гэх 11 дүгээр зууны домгийн хэлцээр үгээр баталгаажуулсан. Д.Е.Еремеев уг үгийг хэл зүйн талаас шинжилж, Скифийн домог дахь анхны хүн Таргидайтай холбосон (Еремеев, Д. Е. 1990) зэрэг олон талаас авч үзсэн боловч төр/state орчуулгын зөрчил болон төрийн инвариант чанарын тухай асуудлыг системтэй судлаагүй байна.

Энэхүү судалгаа нь Монгол төрийн инвариант ойлголтыг түүхэн эх сурвалж, домгийн сэтгэлгээ, нэр томъёоны орчуулгын зөрчил, ардчилал ба уламжлалын огтлолцлын үүднээс шинжилсэн оролдлого юм. Судалгааны явцад уламжлалт төрийн тухай ойлголт нь зөвхөн хууль эрх зүйн институтийн тогтолцоо бус, харин орчлонгийн дэг журам, байгалийн зохиролд уялдсан бүхэллэг шинжтэй болохыг харуулж байна. Энэ нь эцсийн үнэнийг тогтоох зорилготой биш бөгөөд уламжлалт төрийн тухай ойлголтыг илүү өргөн хүрээнд харьцуулсан философийн өнцгөөс тайлбарлах, цаашдын хэлэлцүүлэгт хувь нэмэр оруулахад оршино.

Өгүүлэлийн зорилго: Монгол төрийн инвариант чанарын тухай ойлголтыг тодорхойлох, түүнийг барууны *state* онол, түүний инварианттай харьцуулан шинжлэх, мөн Үндсэн хуулийн төр/state нэр томъёоны орчуулгын зөрчлийг онолын түвшинд тайлбарлах явдал юм. Үүний тулд дараах судалгааны асуултуудыг дэвшүүлэв:

1. Монгол төрийн инвариант чанар гэж юу вэ?, ямар философи, домгийн сэтгэлгээн дээр суурилсан бэ?

2. Энэ ойлголт барууны *state* онолын институцийн ойлголтоос юугаараа ялгаатай вэ?

3. Үндсэн хуулийн “төр/state” орчуулгын зөрчил нь нийгмийн итгэлцэл, улс төрийн легитим байдалд хэрхэн нөлөөлж байна вэ?

Судалгааны ач холбогдол

Өмнөх судалгаанууд “төр” гэх ойлголтыг түүх, хэл шинжлэл, антропологийн өнцгөөс тайлбарласан байдаг. Харин энэ өгүүлэлд “инвариант чанар” гэх философийн суурь ойлголтыг ашиглаж Монгол төрийн уламжлалт “ариун нандин” (сакрал) утга ба орчин үеийн Үндсэн хуулийн хууль эрх зүйн ойлголтын хоорондын системийн зөрчлийг онцлон шинжилснээрээ шинэлэг хувь нэмэр оруулж байна.

Судалгааны хязгаарлалт

Энэхүү судалгаа нь онолын ба түүхэн эх сурвалжийн харьцуулсан шинжилгээнд тулгуурласан бөгөөд эмпирик буюу орчин үеийн нийгэм судлалын судалгаа багтаагүй. Мөн судалгааны төв нь Монголын уламжлалт төрийн үзлийн болон Үндсэн хуулийн орчуулгын зөрчилд чиглэсэн тул өргөн хүрээний харьцуулалт (өөр улс орны туршлага гэх мэт) хийгдээгүй.

II. ОНОЛЫН ҮНДЭСЛЭЛ

Инвариантын философийн суурь ойлголт

Инвариант (лат. *invariant* – “өөрчлөгдөшгүй”) хэмээх нэр томъёо нь аливаа үзэгдэл, системийн хувьсал өөрчлөлтийн дунд өөрчлөгдөхгүй хадгалагдах мөн чанар, тогтвортой шинжийг илэрхийлдэг. Физикт гравитаци хэрхэн бүх хөдөлгөөн дунд тогтвортой оршдог шиг нийгэм, улс төрийн хөгжлийн түүхэнд төрийн инвариант чанар цаг хугацаа, түүхийн хувьсал дунд тогтвортой хадгалагддаг гол шинж болж оршдог (Cassirer, Ernst. 1944).

Байгалийн хууль ба тэнгэрийн хууль

1. Цицерон *ius naturale* буюу байгалийн хуулийг бүх ард түмэнд адил үйлчилж, хүний тогтоосон хуулиас ангид орших өөрчлөгдөшгүй зарчим гэж тодорхойлсон байдаг (Cicero. 1999 [45 BCE]). Энэ нь Монголын уламжлалт “тэнгэрийн хууль”-тай дүйцэх ойлголт юм. Эртний жишээгээр авч үзвэл Хүннүгийн Шанью Хань улсын хаанд илгээсэн захидалдаа: “*Тэнгэрийн ивээлээр тогтоогдсон Их Хүннүгийн Шанью...*” хэмээн төрийн хууль ёсны эх сурвалжийг тэнгэрийн заяанд холбон тодорхойлсон байдаг (Sima Qian. *Shiji*, vol. 110, p. 2896). Bryan K. Miller-ч (Sima Qian. *Shiji*, vol. 110, p. 2896) энэхүү эх сурвалжийг тайлбарлахдаа төрийн эрх мэдэл нь хүний зохиосон механик бүтэц биш харин “тэнгэрийн заяа”-тай холбогдсон байсныг онцолдог. Иймээс төрийн инвариант зарчим түүхэн эх сурвалжид ч хадгалагдан, төрийн хууль ёсны эх сурвалжийг тэнгэрийн хуультай салшгүй холбосон уламжлал эртнээс тогтож ирснийг харуулж байна. К.Хамфригийн тэмдэглэснээр **törü** (төр) хэмээх ойлголт нь Монголчуудын төрийн ухамсарын суурь үзэл баримтлал байжээ. “Монголын нууц товчоо”-нд уг нэр томъёо 8 удаа хэрэглэгдсэн бөгөөд бүгд Чингис хааны байгуулсан улс төрийн бүтэцтэй холбогддог. Эрдэмтэд **törü-г зөвхөн улс төрийн институц биш харин “өндөр зарчим”, “дээд хууль”, ёс заншил” гэсэн утгаар тайлбарладаг. Энэ нь хаанаас ч давсан, хаан түүнд ч захирагддаг, хүнээс үл хамаарах тэнгэрийн тогтоосон хууль буюу бүхнийг хамарсан дэг журам гэж ойлгогдож иржээ. Эртний түрэг хэлэнд **törü** нь **dharma**, өөрөөр хэлбэл бүхнийг захирсан космик шударга ёсны дэг**

журмыг илэрхийлж байсныг тэмдэглэсэн байдаг (Хамфри, К. Хүрэлбаттор. А, -2004). Иймээс монгол төрийн уламжлал дахь тōgū ойлголт нь зөвхөн улс төрийн эрх мэдэл төдийгүй орчлонгийн дэг журам, тэнгэрийн хуультай холбогдсон цогц үзэл байв.

Домгийн үеийн сэтгэлгээ

Домгийн үеийн сэтгэлгээ (*mythological thinking*) нь хүн төрөлхтөний оюуны хөгжлийн эртний хэлбэр бөгөөд аливаа нийгмийн дэг журам, төрийн тогтолцоо нь “ариун эхлэл”-тэй холбогдож, орчлонгийн хуультай нэгтгэгддэг гэж үздэг. К.Элиаде домгийн сэтгэлгээг аливаа үзэгдлийн жинхэнэ мөн чанарыг *illud tempus* буюу “анхны ариун цаг хугацаа” руу буцаж очих замаар тайлбарлагддаг гэж үзсэн (Элиаде Мирча, орч.Ж.Отгонбаяр 2020). Энэ нь Монгол уламжлалд төрийг тэнгэрийн заяанаас үүдэлтэй “тэнгэрийн хууль”-аар баталгаажсан гэж үздэг нь энэ домгийн логикийн илэрхийлэл юм. “Улс мөхөвч төр үлдэнэ” гэх эртний нүүдэлчдийн хэлц үг нь төрийг цаг, хугацаа, нийгмийн өөрчлөлтөөс үл хамаарах инвариант зарчим болохыг гэрчилдэг. Харин К.Юнгийн хамтын ухамсарын онолоор ард түмний ухамсарын гүн дэхь төрийн тухай архитепүүд олон үе дамжин хадаглагдаж, тодорхой нөхцөлд “сэргээгдэн ил гардаг (Юнг Карл. пер. Чечин А.А 2021). Монголчуудын төрийн туг сүлд бол хамтын ухамсарт шингэсэн ийм архетипийн тод жишээ юм.

Э.Кассирер домгийн сэтгэлгээг хүний оюун ухааны бэлэгдэл бүтээх чадавхийн үндсэн хэлбэрүүдийн нэг хэмээн тодорхойлсон бөгөөд улс төрийн эрх мэдлийн легитим байдлыг тайлбарлахад ашиглагддаг гэжээ (Cassirer, Ernst. 1944). Энэ нь Монголын уламжлалт төрийн эрх мэдлийг зөвхөн хүчирхийлэлийн бус, харин тэнгэрийн

хуультай холбож ирсэн үзэл санаатай нийцэж байна.

Нэмж хэлэхэд домгийн үеийн сэтгэлгээ нь байгаль, хүн, нийгмийг салангид бус, бүхэллэг (*холист*) хандлагаар авч үздэг. Энэ нь орчин үеийн системийн онолын чиг хандлагатай дүйцэх талтай бөгөөд Ф.Капрагийн “амьд систем” хэмээх ойлголтод нийцэж байна (Капра.Ф. Луизи П.Л., пер.с.англ. переводные книги, 2022). Энэ үүднээс Монгол төрийн уламжлал- газар, ус, бэлчээр, тэнгэрийг төрийн үндэс гэж үздэг сэтгэлгээ нь системийн онолтой гүн уялддаг. Төрийн инвариант чанарыг зөвхөн эрх зүйн хүрээнд бус экосистемийн зохицол, бүхэллэг харилцааны түвшинд тайлбарлах боломжийг Капрагийн онол нээж өгч байна.

Суверен эрх мэдлийн онол: Жон Боден

Ж.Боден суверен эрх мэдлийг “бие даасан, хязгааргүй, хуваагдашгүй” гэж тодорхойлсон (Bodin, Jean. 1992.). Энэ нь төрийн институци, хууль тогтоомжийн механик бүтцээр илэрхийлэгдсэн бол Монголын эртний уламжлалд төрийн суверен чанар нь тэнгэрийн хууль, байгаль, хамтын ухамсарын дотоод зохицолд тулгуурлаж байжээ.

Рациональ сэтгэлгээ: Рене Декарт

Барууны рациональ уламжлалын суурь болсон Р.Декарт аливаа мэдлэгийг эргэлзээгүйгээр баталгаажуулахын тулд “би бодож байна, тэгэхээр оршиж байна” гэсэн зарчмыг дэвшүүлж, рациональ сэтгэлгээг шинжлэх ухаан, нийгмийн байгууллын үндсэн арга болгон хөгжүүлжээ (Descartes, René. 1998). Тэрээр нийгмийн дэг журмыг “математиктай адил тодорхой системтэй” байх ёстой гэж үзсэн нь барууны улс төрийн онолд төрийн салангид, механик институцийн бүтэц гэж ойлгоход нөлөөлсөн. Монголын уламжлалт төрийн холист, бүхэллэг үзэлтэй харьцуулахад Декартын рациональ уламжлал нь задлан

шинжлэх арга барилыг иүлл эрхэмлэсэн гэдгээрээ ялгардаг.

Хэл зүйн баталгаа

Монгол хэлний хорин наймт толь бичигт (XVIII зуун) төрийг: “Төв дүрэмт засаг тогтож, түмэн иргэнийг амаржуулан дэлхий дахинаа дөрвөн далайн дотоодыг эзэлснийг төр хэмээмэй” (Хорин наймтын толь бичиг. (XVIII зуун), эмхл.Намжилмаа, Хөх хот, ӨМАХХ., 1994) хэмээн тодорхойлсон байна. Энэ нь төрийг төв буюу бүхэллэгийн цөмийн зарчим, бүхнийг зангидагч хүч хэмээн ойлгож байсныг харуулна. Мөн С.Е. Маловын толь бичигт “төрт ёс” нь **дөрөвт ёс** гэсэн утгатай болохыг тэмдэглэсэн нь төрийг орон зай, цаг хугацааг бүхэлд нь тэгшитгэгч архетип ойлголт болохыг гэрчилнэ (Малов, С. Е. 1959).

“Сүлд”-ийн философи

Монгол төрийн инвариант ойлголтод “сүлд” онцгой байр суурь эзэлдэг. “Сүлд” нь “зүлд” буюу амьтны дотор эрхтэнтэй холбоотой гарал үүсэлтэй бөгөөд амин энерги, сүнслэг эхийн илэрхийлэл юм. Монгол төрийн хар, цагаан сүлд тугийг адууны дэлээр хийдэг нь хар,цагаан азарганы дэлийг “сүнсний сав” гэж үздэг уламжлалтай холбоотой. Нэг туг үс нь овог, доторхи нэг хялгас нь хувь хүн, олон туг үсний багц нийлээд олон овог, аймгийг илэрхийлдэг. Энэ бүтэц нь фрактал буюу бутархай хэсэг нь бүхэллэг хэсгийг агуулдаг шинжлэх ухааны онолтой дүйцэж, төрийн хамтын ухамсар дахь инвариант чанарыг илэрхийлдэг.

Ийнхүү Монгол төрийн инвариант ойлголт нь философийн (байгалийн хууль), домгийн (тэнгэрийн заяа), хэл зүйн (хорин наймт толь бичиг, Маловын судалгаа), сакрал (туг, сүлд бэлэгдэл) түвшний огтлолцоолоор бүрэлдэн тогтсон нэгэн цул ойлголт юм.

Respublica, “улс” ба орчуулгын зөрчил

Барууны улс төрийн уламжлалд respublica нь “нийтийн хэрэг”, иргэдийн хамтын ашиг сонирхлыг илэрхийлдэг бол орос уламжлалд энэ үгийг государство гэж хөрвүүлж, язгуурын утгаараа “государь”-ын эзэмшил, ноёрхлын эрх мэдэлтэй холбон хэрэглэж иржээ. Монгол Улсын 1924 оны Үндсэн хууль Чингисийн угсааны хаант эрх мэдлийг халж, төрийг “улс” буюу respublica хэлбэрээр тунхагласан нь улс төрийн философийн томоохон шилжилт байсан.

Социалист Үндсэн хуулиудын онолын суурь

1924, 1940, 1960 оны Үндсэн хуулиуд хэлбэрийн хувьд respublica буюу “улс” гэсэн нэршил (Монгол Улсын Үндсэн хууль. 2004) хэрэглэсэн боловч үзэл суртлын суурь нь Марксизм-Ленинизмын ангич онол байлаа. Энэ онолд төрийг ангийн тэмцлийн хэрэгсэл, пролетарийн диктатурын илэрхийлэл гэж үздэг. Иймээс төрийн эрх мэдэл бүх ард түмнийх бус харин хөдөлмөрчин ангийн нэрийн өмнөөс нэг намын удирдлага дор хэрэгжиж байсан. Иймээс социалист Үндсэн хуулиудад төрийн ойлголт нь хоёрдмол шинжтэй болжээ. Хэлбэрийн хувьд бүгд найрамдах улс мэт боловч агуулгын хувьд ангийн хэрэгсэл, намын аппарат болж хувирсан. Энэ нь уламжлалт Монгол төрийн инвариант ойлголттой зөрчилдсөн. Уламжлалт төр нь тэнгэр-газар-хүн гурвыг зангидах амьд тогтолцоо байхад социалист онолд төрийг ангийн хэрэгсэл болгон хумиж өгсөн нь системийн тасалдлын эх үүсвэр болсон.

Харьцуулсан онолын хүрээ

Барууны улс төрийн онол дахь state нь голчлон хууль эрх зүйн институци, нийгмийн гэрээ болон өмчийн эрхийг хамгаалах зарчимд тулгуурладаг. Харин Монголын уламжлалт төрийн ойлголт нь домгийн сэтгэлгээ, хамтын ухамсар, орчлонгийн дэг журам, тэнгэр-хүн-газрын зохиролд суурилсан, экосистемийн бүхэллэг амьд систем юм.

Тиймээс хоёр өөр соёлын хүрээн дэх төрийн тухай ойлголтыг харьцуулан судалснаар Монгол төрийн инвариант чанарыг тодруулах боломжтой болж байна.

III. АРГА ЗҮЙ

Энэхүү судалгаанд олон эх сурвалжийг харьцуулан судлах харьцуулсан шинжилгээний арга, түүх-соёлын задлан шинжилгээ, мөн философийн онолын тайлбарлал ашиглав. Эх сурвалжид суурилсан текстлогийн шинжилгээгээр Монголын уламжлалт төрийн ойлголтыг илрүүлж, барууны улс төрийн онолын эх сурвалжтай харьцуулсан. Үүний зэрэгцээ орчин үеийн системийн онол, хамтын ухамсар, домгийн сэтгэлгээний онолын хүрээнд холист тайлбар хийв.

Түүхэн эх сурвалжийн шинжилгээ

Монголын төрийн тухай ойлголтыг түүхэн эх сурвалжид хэрхэн тэмдэглэсэн болохыг судаллаа. Үүнд: Хүннү-гийн Шаньюгийн Хан улсын хаанд бичсэн захидал, Монголын нууц товчоо, Их засгийн хуулийн олдсон хэсгүүд, XVIII зууны монгол хэлний Хорин наймт тайлбар толь бичиг, С.Е.Маловын “Памятники древнетюркской письменности Монголии и Киргизий”, Инжи зэрэг судалгааны эх сурвалжуудыг хамруулсан. Эдгээр эх сурвалжууд төрийг “тэнгэрийн хууль”, “дөрвөн зүг”, орчлонгийн үүсэл, “төв”, “цөм”, газар орны зан амьсгал зэрэг домгийн ба онтологийн хэмжээсээр илэрхийлснийг шинжилсэн.

Философийн онолын харьцуулалт

Төрийн инвариант чанарыг тодорхойлохдоо философийн онолуудыг ашиглав. Үүнд: Цицероны *ius naturale* буюу байгалийн хууль, М.Элиаде-гийн ариун орон зай, цаг хугацааны онол, Карл Юнгийн хамтын ухамсар ба архитепийн ойлголт. Эдгээр онолуудыг Монголын уламжлалт төрийн ойлголттой уялдуулан тайлбарлаж,

төрийн инвариант чанар нь хүний тогтоосон хуульд бус орчлонгийн дэг журамд суурилдаг болохыг харуулсан.

Харьцуулсан улс төрийн шинжилгээ

Барууны улс төрийн онол дахь *state* ойлголт (Ж.Локк, Ж.Боден, Маккиавеллийн онол, Вестфалийн тогтолцоо, 1933 оны Монтевидео конвенц, Р.Декарт) болон Монголын уламжлалт төрийн ойлголтыг харьцуулан шинжилсэн. Үндсэндээ барууны *state* нь өмч, нийгмийн гэрээ, эрх зүйн механик бүтцэд суурилдаг бол Монгол төрийн уламжлал нь тэнгэр-хүн-газар гурвалсан зохирол, сүлд, бэлгэдэлд тулгуурладаг ялгаа тодорхойлогдов.

Орчуулгын судалгаа

1924, 1940, 1960, 1992 оны Үндсэн хуулийн текстэд төр /улс/ *state/ respublica* гэсэн нэр томъёог хэрхэн хэрэглэснийг судалж, “төр” ойлголтыг барууны *state*-тэй дүйцүүлсэн орчуулгыг шинжилсэн. Энэ нь судалгааны гол парадоксын (инвариант тасалдлын зөрчил) эх үүсвэр болж байгааг тогтоосон.

IV. СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Домгийн үеийн сэтгэлгээ дэх төр

Монголчуудын домгийн үеийн сэтгэлгээнд төр хэмээх ойлголт нь бүх орчлонгийн эхлэл, зохирол, дэг журмын илэрхийлэл байв. “Төрөх” үйл үгнээс гаралтай энэ нэр томъёо нь зөвхөн хувь хүний мэндэлсэн мөчөөс гадна овог, аймаг, газар орны үүсэл, тэнгэрийн хүсэл, ертөнцийн бүтэцтэй салшгүй холбогдсон ариун нандин тогтолцоо байжээ. Тиймээс төр нь хувьсал өөрчлөлтийн дунд тогтвортой хадгалагдах **инвариант зарчим** болон оршсон байна.

Домгийн сэтгэлгээний гол шинж нь бүхэллэг (холист) шинжтэй байсан байна. Хүн, газар нутаг, төр гурвыг салангид бус, харин нэгэн бүхэллэг системийн ялгаатай хэмжээсүүд хэмээн ойлгож байв. Энэ нь орчин үеийн шинжлэх ухаанд хэрэглэгддэг

“фрактал”/ “голограф” бүтэцтэй адил: бүхэллэгийн нэг хэсэг бүрт бүхэл орших, хэсэг ба бүхэл нь салшгүй холбогдсон байх зарчим юм. Жишээлбэл, төр нь нэг талаас гэр бүл, овог, аймгийн зохион байгуулалтын хэлбэрийг илэрхийлэхийн зэрэгцээ нөгөө талаас тэнгэр-хүн-газрын гурвалсан зохирлыг илэрхийлдэг. “Улс мөхөвч төр үлдэнэ”, “Өрх гэрт төрт ёс тогтвол улс гэрт төрт ёс тогтоно” гэсэн нүүдэлчдийн хэлц үгнүүд нь төр бол хувь хүн болон байгууллын хил хязгаараас давсан, ертөнцийн хуультай дүйцэх инвариант зарчим юм гэдгийг баталгаажуулав.

Үндсэн хуулийн орчуулгын зөрчил

Монголын түүхэн хөгжлийн туршид төр болон улс хэмээх нэр томъёоны хэрэглээ үе үеийн Үндсэн хууль болон эрх зүйн баримт бичгүүдэд өөр өөрөөр буусан нь өнөөгийн зөрчлийн уг үндэс болж байна.

- 1924, 1940 оны Үндсэн хуульд латин гаралтай *respublica* гэх нэр томъёог “улс” гэж орчуулсан нь Чингисийн угсааны хаанчлалын уламжлалаас бүгд найрамдах улсын хэлбэрт шилжсэнийг илэрхийлжээ. Энэ үед латин гаралтай *respublica*-гийн агуулгыг шууд авч хэрэгжүүлсэн бус харин оросын “государство” гэх нэр томъёогоор дамжуулан “улс” гэж орчуулсан. Түүхэн нөхцөл байдлаас шалтгаалан энэхүү ойлголт Марксист Ленинист үзэл суртлын ангич онолд суурилж, *respublica*-гийн анхны агуулгыг гажуудуулан хүлээн авсан. Үүний улмаас төр=улс гэх ойлголт зөвхөн улс төрийн аппарат, ангийн дарангуйллын хэрэгсэл гэсэн үзэл рүү хазайсан нь өнөөгийн зөрчлийн эхлэл болсон юм.

- 1960 оны Үндсэн хуульд (Монгол Улсын Үндсэн хууль. 2004) “улс” болон “төр” гэсэн хоёр нэр томъёог хослуулан хэрэглэсэн нь онцлог. Жишээлбэл, төрийн байгуулалтын зарчимд “төр” гэх нэр томъёо хэрэглэхийн зэрэгцээ өмчийн

харилцаанд “бүх газар улсын өмч” гэх заалт орсон хэвээр байв (Үндсэн хууль 1960 10 дугаар зүйл). Энэ нь төр ба улс хоёрын хэрэглээг системтэйгээр зааглаж чадаагүй хос давхар ойлголтын үндсийг тавьж, “төр” гэх ариун сакрал утга бүдгэрсэн. Үүний улмаас эрх мэдлийн аппаратын ойлголтоор хэрэглэгджээ.

- 1992 оны Үндсэн хуульд барууны улс төрийн онолын *state* нэр томъёог бүрэн дүүрэн “төр” гэж орчуулсан. 1992 оны Үндсэн хуулийн төслийг хэлэлцсэн Ардын Их Хурлын чуулганы хуралдааны хэлэлцүүлэгт энэ сонголтыг “унаган хэлээ авах” гэж тайлбарласан байдаг (Монгол Улсын Их Хурал. 2017).

Ингэснээр уламжлалт “төр” (сакрал/ ариун нандин) ойлголт, социалист үеийн “улс” үзэл болон *state* (хууль эрх зүйн механик бүтэц)-ийн гурван өөр онтологийн түвшинд давхцан орж, системийн түвшний үл ойлголцол бий болгосон.

Ардчилсан уламжлалын огтлолцол

Монголын ардчилсан уламжлал барууны *democracy* ойлголттой шууд давхцахгүй ч уламжлалт төрийн инвариант зарчимтай огтлолцож орчин цагийн хэлбэрээ олжээ. Үндсэн хуулийн оршил хэсэгт “Монголын ард түмэн бид ...төрт ёсны түүхэн уламжлалаа нандигнан өвлөнө...” гэсэн мөрүүд орсон нь ардчилсан төрийн байгуулал болон домгийн үеийн ариун нандин (сакрал) төрийн хооронд **гүүр** болж өгчээ. Энэ нь зөвхөн эрх зүйн эх сурвалжийн түвшинд бус, соёл-онтологийн түвшинд ч ардчилалыг үндэсний уламжлалтай уялдуулах оролдлого байсан. Монгол төрийн бэлэг тэмдэг нь ардчилсан уламжлалын тод жишээ юм. Төрийн хар,цагаан сүлд туг нь зөвхөн улс төрийн институцийн бэлгэдэл бус, орчлонгийн дэг журам, төрт ёсны “дөрвөн зүг” (Малов, С. Е. 1959.) гэсэн архетипийг илэрхийлдэг. Төрийн сүлд тугийг төрийн албан ёсны бэлэг тэмдэг болгон

хэрэглэхдээ ард түмэн “төрийн минь сүлд өршөө” гэх уламжлалт залбирлаар хүндэтгэсээр ирсэн нь ардчилсан тогтолцоонд ч (*Үндсэн хууль 1992 12*) хадаглагдан үлджээ.

Иймээс ардчилсан тогтолцоо Монголын эртний уламжлалт төрийн инварианттай уялдсан тохиолдолд л нийгмийн итгэлцлийг хангаж чадна.

Монгол төрийн инвариант ойлголтыг уламжлалт сурвалжуудаар тодорхой харуулж болно. Эдгээр эх сурвалжид төрийг төв, дөрвөн зүг, туг-сүлд, тэнгэрийн хууль, газар орны зан амьсгал зэрэг архитектур хэмжээсүүдээр илэрхийлсэн байдаг. Үүнийг дараах хүснэгтэд нэгтгэн харуулав.

Хүснэгт 1. Монголын уламжлалт төрийн инвариант ойлголт

Эх сурвалж/ онол	Гол агуулга	Инвариант чанар	Жишээ эх сурвалж
Хүннүгийн Шаньюгийн захидал (МЭӨ II зуун)	Хаан өөрийгөө “тэнгэрийн ивээлээр тогтоогдсон” гэж тодорхойлсон	Хааны эрх мэдлийн легитим эх сурвалж нь өөрийн хүсэл зоригт бус орчлонгийн дэг журмаас эхтэй	<i>Сыма Цянь, Shiji, 110: 2896, Miller 2009</i>
Монголын нууц товчоо (XIII зуун)	Есүй хатны үг”тулгар төрийн чинь туг, сүлд”-ийг хэн барих вэ?	Төрийн сүлд: Газар, усны онгод, тэнгэрийн хүчин, хааны заяа гурвын нэгдэл. Энэ гурвыг сүлд төлөөлдөг.	<i>МНТ, & 254 2022</i>
Чингис хааны Их засаг хууль	“...бэлчээр шатаавал гэр бүлээр нь цаазлах”	Байгальтай адил салшгүй инвариант	<i>Н.Ням-осор, 2003 (“Их засаг хуулийн олдсон хэсгийн түүвэр. 2003)</i>
Монгол хэлний “хорин наймт тайлбар толь”	“Төв дүрэмт засаг тогтон түмэн иргэнийг амаржуулан дэлхий дахинаа дөрвөн далайн дотоодыг эзэлснийг төр гэнэ”	Төрийн анхны үүсэл буюу мэдээллийн цөм, Мэдээллийн төвлөрөл бий болсноор түмэн олны энерги төвлөрч, дотоод зохицлыг орчлонгийн хэмжээнд тэлэх тухай юм	<i>Хорин наймт толь, 1994 (Хорин наймтын толь бичиг. (XVIII зуун), эмхл.Намжилмаа, Хөх хот, ӨМАХХ., 1994)</i>
Хөх судар	Тэнгэр заяат хаан хүн газар орны амьсгалаар олныг энхжүүлнэ.	Газар= амьд импульс бүхий инвариант	<i>Инжинааш, 2009</i>
С.Е. Малов, Памятники древнетюркской письменности Монголии и Киргизии	“Төрт -четыре- дөрөв	ертөнцийн дөрвөн зүг	<i>Малов, 1959</i>
Ардын уламжлал	Дээлийн зах хаашаа дөрвөн хормой тийшээ	Олонлогийн бүхэллэг, фрактал зохирол	<i>Монгол ардын хэлц үг</i>
Дөрвөн талт жанжин малгай	Төв ба дөрвөн талын бэлгэдэл	Олонлогийн бүхэллэг, фрактал зохирол	<i>Орчин цагийн хэрэглээ</i>
Чингис хааны музей (<i>загвар</i>)	“Түмэн амгалант” хэмээх ордны дотор талд хаан сэнтийн өмнөх талбайд Мөнгөн модны оройд бишгүүрт хүү, дөрвөн буланд арслан цорготой, идээ ундааны ундарга	Төв багана ба дөрвөн зүг: төрийн бүхэллэгийн инвариант	<i>Мөнгөн модны загвар Чингис хаан музейд байрладаг</i>
Монголын нүүдэлчдийн амьдралын цикл	Нутаг усаа өвөлжөө, хаваржаа, зуслан,	Байгалийн мөчлөгт уялдсан зохирол,	<i>Н.Хавх, 199</i>

	намаржаа гэж дөрвөн хэсэгт хуваан нүүдэллэж, улирлын зохиролд нийцүүлэн амьдрах	нүүдэл, суудлын инвариант	
Монголын газар нутгийн эзэмшил	Газар нутаг нийтийн эзэмшилд байсан нь чөлөөтэй нүүдэллэх, байгальтай зохицон амьдрах үндэс болсон.	Газар бол өмч бус, амьдралын нөхцөл ба соёлын суурь Газар бол оршихуй	Н.Хавх, 1995

Хүснэгт 2. Монголын уламжлалт төрийн инвариант ба барууны state онолын харьцуулалт

Эх сурвалж/ онол	Барууны state / инвариант	Монгол төрийн инвариант
Жон Локк, Two Treatises of government (1690) өмчийн онол	"Terra nullius", эзэнгүй газар нь хөдөлмөрлөсөн хүнд өмчлөгдөнө (Locke, John. 1690).	Газар бол өмч бус, амьд энерги, мэдээлэлтэй, оршихуй, төрийн үндэс
Жан Боден, Суверен эрх мэдлийн онол (1576)	Суверен эрх мэдэл:- Биеэ даасан, хязгааргүй, хуваагдашгүй. Энэ нь институцийн механик бүтцээр илэрхийлэгдсэн (Bodin, Jean. 1992).	Хаан хүртэл тэнгэрийн хуульд захирагдана. Эрх мэдэл хязгаартай, сакрал шинжтэй, хуваагдашгүй байдал нь төр=төв ойлголтоор илэрнэ.
Никколо Маккиавелли, Государь (1532) эрх мэдлийн онол	төрийн гол тулгуур нь ёс суртахуун бус, харин эрх мэдлийн бодит хүч (Макиавелли, Никколо. Государь. Москва: Художественная литература, 1982)	Ёс суртахуун төрийн үндэс: төр бол зөвхөн хүч бус сүлдэн дээр тогтодог амьд тогтолцоо (Sima Qian. Shiji, vol. 110, p. 2896)
Вестфалийн гэрээ (1648)	Төр тусгаар тогтносон нэгж, (Peace of Westphalia. 1648)	Төр= тэнгэр-хүн-газрын зохирол, эко тогтолцооны бүхэллэг гинж
Монтевидео конвенц (1933)	Төрийн шалгуур: хүн ам, нутаг дэвсгэр, эрх мэдэл, олон улсын харилцааны чадамж (Montevideo Convention on the Rights and Duties of States. 1933)	Нүүдэлчдийн төр: газар, ус, бэлчээр, улирлын мөчлөг дээр суурилсан, амьд циклтэй тогтолцоо (Хавх. Н , 1995)
Эрх зүйн философи	Хүний эрх, эрх чөлөө нь Христийн иашны натур эрх-д тулгуурласан	Байгалийн хууль буюу орчлонгийн жам ёс (Cicero. 1999) (Sima Qian. Shiji, vol. 110, p. 2896)
Инвариант чанар	Декартын рациональ сэтгэлгээ аливааг хэсэгчлэн шинжилдэг механик тогтолцоо. Хүн, байгаль тусдаа. Хүн байгалийг захирч чадна (Descartes, René. 1998.)	Нэг цул бүхэллэг сэтгэлгээ, хүн, байгаль хүйн холбоотой. Хүн байгалийн нэг хэсэг[9]

Инвариант тасалдлын парадокс

Дээрх хоёр хүснэгтээс харахад Монголын уламжлалт төрийн инвариант ойлголт нь төрт ёс= дөрвөн зүг, төв цэг-орчлонгийн зохирол, тэнгэр-хүн-газрын зохирол, газар орны импульс гэсэн логик дээр тогтож, нийгэм-улс төрийн төдийгүй соёл-онтологийн тогтолцоог

нэгтгэж байжээ. Энэ утгаар төрийн туг, сүлд нь орчлонгийн төвийг тогтоон дөрвөн зүгийг холбосон улсын амин сүнс болсон амьд төрийн инвариант системийн дүрслэл болж байна. Харин барууны state онолын уламжлалд Ж.Локкийн газар өмчлөх эрхийн сургаал бол state-ийн тогтвортой суурь үзэл

санаа бөгөөд өмчлөх эрх нь хүний эрх, эрх чөлөөний баталгаа гэж үздэг бөгөөд эрх мэдлийн хүчээр баталгаажсан, нутаг дэвсгэрээр зааглагдсан институцийн бүтцээр тодорхойлогддог. Эдгээр **хоёр өөр инвариантын огтлолцол Монгол Улсын Үндсэн хуульд “төр” гэсэн нэг нэр томъёонд давхцан хэрэглэгдсэнээр онтологийн түвшний зөрчил үүсгэжээ.** Үүнийг энэхүү судалгаанд “инвариант тасалдлын парадокс” гэж тодорхойлж байна.

Нэг талаас ард түмний ухамсарт төр нь “өршөөгч, хамгаалагч” гэсэн сүлдэн ойлголт хэвээр оршсоор байгаа бол нөгөө талд улс төрийн практикт төр нь хууль, өмч, институцийн бүтэц болж хэрэгжиж байна. Энэ хоёрын давхцал нь нийгмийн итгэлцэл, легитим чанарт зөрчил үүсгэдэг.

Хэлэлцүүлэг

Өмнөх судалгаанууд төрийг ихэвчлэн салангид өнцгөөс тайлбарласан байдаг. Жишээлбэл: зарим нь төрийг тэнгэрийн хууль, зарим нь дөрвөн зүг, зарим нь сүлд туг, хүний үүсэл, эхлэл гэх мэтчилэн онцлон авч үзсэн. Харин энэхүү судалгаа эдгээрийг **холист, фрактал, голограф** сэтгэлгээний хүрээнд нэгтгэн шинжилж, төрийг бүхэллэг ойлголт болохыг тогтоосон. Үүний үр дүнд дараах гурван гол санаа тодорч байна:

1) **Төрийн бүхэллэг ойлголт.** Төр бол газар, хүний ухамсар, байгаль гурвыг нэгтгэсэн цогц систем. “Төрөх үүсэх” нь орчлонгийн бүтцийн фрактал хэлбэр, төрийн эрх мэдэл нь тэнгэрийн хуультай холбоотой, төр бол орчлонгийн дөрвөн зүгийг илэрхийлнэ. Энэ бүхнийг нэгтгэн үзвэл эртний монгол уламжлалт төр бол бүхэлдээ инвариант тогтолцоо юм.

2) **Орчуулгын зөрчил ба өнөөгийн хямрал.** State-ийг “төр” гэж орчуулсан нь сакрал ойлголт ба институцийн механик бүтцийг нэг нэр дор нийлүүлсэн. Энэ зөрчил нь өнөөдөр

уул, уурхайн бодлого, газар нутгийн асуудал, шүүхийн шударга бус байдал, иргэдийн төрд итгэх итгэл алдагдах зэрэг бодит хямралд хүргэж байна. Малчид бэлчээр усны хомсдолд орж, уламжлалт оришхуй алдагдаж, нийслэлд шилжиж ирсэн ч амьдрах аргагүй болсон нь энэ зөрчлийн шууд үр дагавар юм. Чингис хааны Их засгийн хуулийн олдсон хэсэгт “...бэлчээр шатаасан хүнийг гэр бүлээр нь хамт алах...” хэмээн хатуу хуульчилсан нь **бэлчээр, ус бол зөвхөн эдийн засгийн нөөц бус, амьдралын амин инвариант** байв. Э.Тоффлерийн үзлээр үндэстэн-төр (nation-state) бол аж үйлдвэржилтийн эрин үеийн зохиомол бүтэц бөгөөд эдийн засаг, бодит улс төрийн ашиг сонирхлыг нэгдүгээрт тавьж, газар орны сүнслэг импульс, оюун санааны хүчин зүйлсийг үл тоомсорлодог[24] гэж онцолсон байдаг.

Цаашдын чиглэл. Ямар ч нийгэм, улс инвариант чанараа олохгүй бол хөгжлийн гацаанаас гарч, сэргэн мандах боломжгүй. Энэ судалгаа төрийн инвариант чанарыг тогтоож, зүг чигээ тодорхойлох онолын суурь болж байна. Энэхүү судалгааг улам хөгжүүлэхийн тулд:

-Монгол төрийн инвариант ойлголтыг бусад төв евроазийн ард түмний уламжлалт төрийн үзэлтэй харьцуулсан түүхийн судалгаа хийх

-Орчин үеийн хууль тогтоомж, Үндсэн хуулийн өөрчлөлтөд уламжлалт төрийн инвариант ойлголтыг хэрхэн тусгах боломжтойг эрх зүйн философийн түвшинд судлах

-Иргэдийн төрийн талаарх өнөөгийн ойлголт, хандлагыг социологийн болон антропологийн аргаар тогтоох

VI. ДҮГНЭЛТ БА САНАЛ

Энэхүү судалгаагаар Монгол төрийн тухай уламжлалт ойлголт нь зөвхөн улс төрийн байгуулал бус орчлонгийн дэг журмын тусгал дүр, тэнгэр- хүн- газрын

зохирол дээр тогтсон бүхэллэг бүхнийг хамарсан нэгэн цул систем болохыг илрүүлэв.

Төрийн инвариант чанар нь дараах гурван үндсэн түвшинд илэрч байв:

1) Домгийн үеийн түвшин- төр бол төрөх, үүсэх, бүхэллэгийн эхлэл, шинэ бүтэц бий болох.

2) Соёл-онтологийн түвшин- төр бол ертөнцийн дөрвөн зүг, төв, цөм: туг сүлд нь улсын амин сүнс, энерги.

3) Эрх зүйн түвшин- төр бол орчин үеийн институцийн эрх мэдэл биш орчлонгийн дэг журмын удирдлагын хүний нийгэмд илэрсэн дүр төрх.

Эдгээр түвшинг нэгтгэж үзвэл төрийн инвариант чанар нь фрактал-голограф бүтцийн зарчмаар ажиллаж, хувь хүн, овог, аймаг, гүрэн улс, орчлон гэсэн ялгаатай хэмжээсүүдэд ижил эх зарчим үйлчилдэг болохыг харуулж байна.

Энэ нь төрийг зөвхөн институцийн түвшинд бус бүхэллэг системийн түвшинд авч үзэх боломжийг нээж байна. Гэвч энэхүү дүгнэлт нь нэг мөр үнэн гэхээсээ илүүтэйгээр төрийн философийг шинээр тайлбарлах, харьцуулсан онолын түвшний оролдлого гэдгийг онцлон тэмдэглэх нь зүйтэй. Цаашид уг сэдвийг гүнзгийрүүлэн орчин үеийн төрийн онолын хүрээнд хэлэлцүүлж, практикт турших судалгааны боломж нээлттэй хэвээр байна.

Санал

Монгол Улсын тогтвортой хөгжил дэвшил нь төрийн инвариант чанарыг зөв тодорхойлон Үндсэн хууль, бусад хууль тогтоомжид тусгахтай шууд холбоотой. Иймд:

1) Үндсэн хууль дахь “төр/state” орчуулгын зөрчлийг шинжлэх ухааны түвшинд дахин авч үзэж, уламжлалт болон орчин үеийн ойлголтыг нийцүүлэх шаардлагатай.

2) Төрийн бэлгэ тэмдгийг зөвхөн хууль зүйн институцийн хүрээнд бус, ард түмний хамтын ухамсарт хадгалагдсан

ариун нандин (сакрал) соёлын суурь утгаар нь хүндэтгэн тайлбарлах нь чухал.

3) Ф.Капрагийн системийн сэтгэлгээний онол зэрэг орчин үеийн шинжлэх ухааны шинэ парадигмуудтай холбон судлах нь гарц шийдэл болох боломжтой. Энэ нь зөвхөн уламжлал, эсвэл ардчилалд туйлшрахгүй төрийг “амьд” систем хэмээн авч үзэж, байгаль, нийгэм, соёлын уялдаа дээр суурилсан дундын эко-хандлагатай шинэ парадигмыг хөгжүүлэх суурь болно.

Ингэснээр Монголын ардчилал, уламжлалт төрийн инварианттайгаа нийцэж, улс орны тогтвортой хөгжил, дэвшлийн шинэ чиг хандлагыг нээх, улс орны эв нэгдэл, төр, ард түмний итгэлцлийг хангах боломжтой юм.

Энэхүү судалгаа нь олон жилийн турш хийсэн судалгаа, ажиглалт, нөр их хөдөлмөр, хичээнгүй тууштай зүтгэлийн үр дүн юм. Судалгааны явцад хуримтлуулсан туршлага, гүнзгий эргэцүүлэл нь Монгол төрийн инвариант чанарыг илрүүлэхэд онцгой түлхэц болсон билээ.

Ашигласан материал

Хамфри, К, Хүрэлбатор. А, -2004 “Значение термина TORU в Монгольской истории”, Улан-Удэ, Институт монголоведение, буддалогии и тибетлогии СО РАН., изд-во: Бурятского научного центра,

Скрынникова, Т. Д. 2000. “Монгольское кочевое общество период империй”, Улан-Удэ: Институт Монголоведения, буддалогии и тибетологии РАН

Еремеев, Д. Е. 1990. “Тюрк”- этноним Иранского происхождения? (К проблеме этногенеза древних тюрков), Москва: Советская этнография. №3

Cassirer, Ernst. 1944. *An Essay on Man: An Introduction to a Philosophy of Human Culture*. New Haven: Yale University Press. Accessed September 10, 2025. <https://archive.org/details/in.ernet.dli.2015.236097>

- Cicero. 1999 [45 BCE]. *De Legibus*. Translated by C. W. Keyes. Cambridge, MA: Harvard University Press.
- Sima Qian. *Shiji*, vol. 110, p. 2896. Quoted in Bryan K. Miller, *Power Politics in the Xiongnu Empire*. PhD diss., University of Pennsylvania, 2009.
- Элиаде Мирча, орч.Ж.Отгонбаяр 2020 “Домог зүйн сэтгэлгээ” Улаанбаатар
- Юнг Карл. пер. Чечин А.А 2021 “Отношение между эго и бессознательным” АСТ, ID:833977
- Капра.Ф . Луизи П.Л ., пер.с.англ. переводные книги, 2022 “Системный взгляд на жизнь (целостное представление), ID:276918
- Bodin, Jean. 1992. *On Sovereignty: Four Chapters from The Six Books of the Commonwealth*. Edited and translated by Julian H. Franklin. Cambridge: Cambridge University Press. (Originally published 1576)
<https://doi.org/10.1017/CBO9780511802812>
- Descartes, René. 1998. *Discourse on Method and Meditations on First Philosophy*. 4th ed. Translated by Donald A. Cress. Indianapolis: Hackett Publishing.
- Хорин наймтын толь бичиг. (XVIII зуун), эмхл.Намжилмаа, Хөх хот, ӨМАХХ., 1994, 1611-р тал
- Малов, С. Е. 1959. с.105 “Памятники древнетюркской письменности Монголии и Киргизии”, Москва–Ленинград: Издательство Академии наук СССР
- Монгол Улсын Үндсэн хууль. 2004. *Монгол Улсын Үндсэн хууль: Баримт бичиг*. Эмхтгэж, тайлбар бичсэн Ж. Амарсанаа,
- О. Батсайхан. Улаанбаатар: [s. n.], ISBN 99929-0-308-2.
- Монгол Улсын Их Хурал. 2017. *Монгол Улсын Үндсэн хуулийн төслийг хэлэлцсэн БНМАУ-ын Бага хурал, Ардын Их Хурлын чуулганы хуралдааны тэмдэглэл (1991–1992 он)*. Улаанбаатар: Улсын Их Хурлын Тамгын газар. CD-ROM
- Монголын нууц товчоон. 2020. Б.Сумъяабаатар хөрвүүлэг, Улаанбаатар., “Жиком пресс” ХХК “Их засаг хуулийн олдсон хэсгийн түүвэр. 2003, Н.Ням-Осор, “Мөнх тэнгэрээс соёрхсон Чингис хааны зарлиг буюу Их засаг хуулийн тайлбар”, Улаанбаатар
- Инжаннаши.В, Хөх судар.П.боть., 2009, Улаанбаатар, “Болор судар” хэвлэлийн газар
- Хавх. Н , 1995 Монгол соёл иргэншлийн гүн ухаан, Улаанбаатар хот
- Locke, John. 1690. *Two Treatises of Government*. London: Awnsham Churchill.
- Макиавелли, Никколо. *Государь*. Москва: Художественная литература, 1982. Доступно онлайн: https://www.socioline.ru/files/5/81/nikkolo_makiavelli
- Peace of Westphalia. 1648. *European Treaties*
- Montevideo Convention on the Rights and Duties of States. 1933. *Organization of American States*.
- Тоффлер, Элвин. *Третья волна*. Москва: АСТ, 2004. ISBN: 9785170259773.
- Locke, John. *Two Treatises of Government*. London: Awnsham Churchill, 1690.
<https://plato.stanford.edu/entries/locke-political/>.